



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 228.

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн
оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны
улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид
ногдох хувьцааны ногдол ашгийн
хувь хэмжээг тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын
2021 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Төрийн болон орон
нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн
ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн
2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын
төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн
удирдлага, зохицуулалтын хэлтэс(Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001215

ТӨБЗГ тогтоол-/2021

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний
өдрийн 2 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН
ДҮНГЭЭС ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШГИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

2021 он

№	Компанийн нэрс	2020 оны цэвэр ашиг /мян.төгрөг/	Төрийн өмчийн ногдол ашиг /мян.төгрөг/
1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	263,100,513.00	200,000,000.00
2	ИНЕГ	4,148,813.50	414,881.35
3	"Монголросцветмет" ТӨҮГ	48,211,710.10	4,821,171.01
4	Эрдэнэс МГЛ ХХК	7,666,529.20	766,652.92
5	Автотээврийн үндэсний төв ТӨҮГ	2,196,850.60	219,685.06
6	"УБ Төмөр зам" ХНН	11,250,707.00	1,125,070.70
7	Геологийн судалгааны төв ТӨҮГ	222,610.70	22,261.07
8	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ	1,056,952.30	105,695.23
9	Монголын төмөр зам ТӨХК	362,738.80	36,273.88
10	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	2,785,128.90	278,512.89
11	Монгол шуудан ХК	557,893.34	110,462.88
12	"Эрдэнэтийн ДЦС" ХК	543,496.30	81,524.45
13	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	836,429.90	83,642.99
14	"БЗӨБЦТС" ХК	459,120.70	68,868.11
15	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	593,905.40	59,390.54
16	"Монгол Ус" ТӨҮГ	211,369.40	21,136.94
17	"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ	170,495.00	17,049.50
18	"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ	168,675.20	16,867.52
19	"Монголын цахилгаан холбоо" ХК	43,388.80	24,499.30
20	"Өвөрхангай АЗЗА" ТӨХК	79,046.20	7,904.62
21	"Цагаан шонхор" ТӨҮГ	23,221.90	2,322.19
22	Хөвсгөл АЗЗА ТӨХК	177,567.60	17,756.76
23	Хархорин АЗЗА ТӨХК	44,495.40	4,449.54
24	Дархан АЗЗА ТӨХК	15,230.20	1,523.02
25	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	38,331.90	3,833.19

26	Харгуй ТӨХК	35,774.10	3,577.41
27	Увс АЗЗА ТӨХК	558,453.50	55,845.35
28	Төв АЗЗА ТӨХК	8,671.60	867.16
29	Дорноговь АЗЗА ТӨХК	10,007.70	1,000.77
30	Ховд АЗЗА ТӨХК	72,940.90	7,294.09
31	Багануур АЗЗА ТӨХК	23,742.70	2,374.27
32	Талын зам ТӨХК	2,510.00	251.00
33	Завхан АЗЗА ТӨХК	31,363.20	3,136.32
34	Говь-Алтай АЗЗА ТӨХК	11,910.30	1,191.03
35	Орхон АЗЗА ТӨХК	31,690.40	3,169.04
36	Налайх АЗЗА ТӨХК	975.6	97.56
37	Архангай АЗЗА ТӨХК	191,466.90	19,146.69
38	Диспетчерийн үндэсний төв ХХК	126,049.40	37,814.82
39	Геологийн төв лаборатори ТӨҮГ	118,623.40	11,862.34
40	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	1,448,333.00	144,833.30
41	ХХНОБуудал ХХК	331,381.40	33,138.14
42	Төрийн банк ХХК	30,611,885.00	3,061,188.50
43	Үндэсний давхар даатгал ХК	3,197,499.00	319,749.90
		381,778,499.44	212,017,973.34